

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ”-д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮНГ ТООЦОЖ БАЙХ ШААРДЛАГАТАЙ
БАЙНА.

АУДИТЫН КОД: ГНАГ-2025/06-02-ШТА-НА

Даланзадгад сум

Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Т.Өсөхбаяр
Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Шижирболд
Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn
Аудитор: Э.Жамцдорж
Цахим хаяг: Jamtsdorje@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлал.....	2
Хүснэгтийн жагсаалт.....	2
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх.....	3
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	4
БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ҮНЭЛЖ ЭРЭМБЭЛЭЭГҮЙ БАЙНА.....	5
БҮЛЭГ 2. ЗАХИАЛАГЧ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТЫГ БОЛОВСРУУЛЖ, БАТЛАХДАА ХОЛБОГДОХ МЭРГЭЖИЛТНҮҮДИЙГ ОРОЛЦУУЛЖ БАЙХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....	6
БҮЛЭГ 3. ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ АШИГЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.....	9
ДҮГНЭЛТ.....	13
ЗӨВЛӨМЖ.....	14
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....	15

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ГБХНХ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаалал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ШТА	Шууд тайлагнах аудит
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХХК	Хариуцлагат хувьцаат компани

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	<i>Эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний мэдээлэл</i>	4
Хүснэгт 2	<i>Төсөл, арга хэмжээний ангилал</i>	5
Хүснэгт 3	<i>Төсөл, арга хэмжээний мэдээлэл</i>	6
Хүснэгт 4	<i>Төсөл, арга хэмжээний мэдээлэл</i>	8
Хүснэгт 5	<i>Төсөл, арга хэмжээний мэдээлэл</i>	9

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2024 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилго

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэсэн. Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх?
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх?
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх?

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Өмнөговь аймгийн Засаг даргад эрх шилжиж ирсэн 2024 онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагаа, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, хянах зэрэг судалгааны арга зүйг ашиглалаа.

Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт,
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Засгийн газрын 2021 оны 160 дугаар, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”

- Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”,
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд
- Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон холбогдох бусад эрх зүйн актууд.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Хонгорзул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Шижирболд, аудитор Э.Жамцдорж нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд Өмнөговь аймагт он дамжин хэрэгжих 1, шинээр хэрэгжих 10 нийт 16,852.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 11 төсөл, арга хэмжээг тайлант онд 6,082.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт 1 Эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний мэдээлэл

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Эрх шилжүүлсэн тушаал	Хугацаа		Төсөвт өртөг /сая. төгрөг/	2024 онд санхүүжих дүн /сая. төгрөг/
				Эхлэх	Дуусах		
1	V.3.11	Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Өмнөговь/	11	2024	2024	400.0	400.0
2	XII.1.6	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/	A/371	2024	2026	2,512.5	850.0
3	XII.2.1	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилгын их засвар, цахилгааны монтаж, халаалтын зуухыг шинэчлэх /Өмнөговь, Даланзадгад/	A/38	2024	2024	20.0	20.0
4	XII.2.1	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Архивын барилгын дээврийн засвар /Өмнөговь, Даланзадгад/	A/38	2024	2024	20.0	20.0
5	XIII.1.1.29	Сургуулийн барилга, 320 суудал /Өмнөговь, Цогт-Овоо сум	A/69	2019	2025	4,664.3	542.3
6	XIII.1.3.26	Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Өмнөговь/	A/550	2024	2024	1,150.0	1,150.0
7	XIV.1.1.8	Буянт хотхон хүүхдийн зуслангийн өвлийн байр, 250ор /Өмнөговь, Даланзадгад сум/	409	2024	2026	3,057.9	500.0
8	XVI.2.3.7	Орон нутаг судлах танхимын тоног төхөөрөмж /Ноён сум/	A/499	2024	2024	65.1	65.1
9	XVIII.3.34	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Өмнөговь/	A/14	2024	2024	834.9	834.9
10	XXI.1.47	Зооноз өвчин судлалын төвийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/	A/12	2024	2026	3,427.7	1,000.0
11	XXI.3.20	Эрүүл мэндийн салбарын автомашин, тоног төхөөрөмж /Өмнөговь/	A/12	2024	2024	700.0	700.0
Нийт						16,852.4	6,082.3

Эх сурвалж: Сангийн яам

Дээрх мэдээллээс харахад зарим барилга байгууламжийн тухайн жилд санхүүжүүлэх дүн нь төсөвт өртөгтэй харьцуулахад бага буюу Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.3.4.2¹-г хангахгүй байна.

¹ шинээр эхлэх барилга байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах.

БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ҮНЭЛЖ ЭРЭМБЭЛЭЭГҮЙ БАЙНА.

1.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлсэн жагсаалтыг аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 01/1982 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн байна.

1.2 Тус жагсаалтаар 2,503,264.2 сая төгрөгийн өртөгтэй 43 төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр саналаас шинээр хэрэгжих нэг төсөл, арга хэмжээ буюу “Буянт хотхон хүүхдийн зуслангийн өвлийн байр”-г тусгасан байна.

1.3 Харин Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Өмнөговь аймагт шинээр 10, өмнөх оноос шилжих 1 төсөл, арга хэмжээнд нийт 6,082.3 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тусгасан байна.

Хүснэгт 2 Төсөл, арга хэмжээний ангилал

/сая төгрөг/

Ангилал	Шилжих TAX			Шинэ TAX			Нийт TAX		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга байгууламж	1	4,664.3	542.3	3	8,998.1	2,350.0	4	13,662.4	2,892.3
Их засвар	-	-	-	2	40.0	40.0	2	40.0	40.0
Тоног төхөөрөмж	-	-	-	5	3,150.0	3,150.0	5	3,150.0	3,150.0
ТЭЗҮ	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт	1	4,664.3	542.3	10	12,188.1	5,540.0	11	16,852.4	6,082.3

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

1.4 Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээнүүдэд 2024 онд олгох санхүүжилтийн 51.8 хувийг тоног төхөөрөмж, 47.6 хувийг барилга, байгууламж, 0.6 хувийг их засварт зарцуулахаар төлөвлөсөн байна.

1.5 Төлөвлөсөн тоног төхөөрөмжүүдийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцсон эсэх, тоног төхөөрөмжүүд нэн шаардлагатай байсан эсэх тодорхойгүй байна. Тухайлбал:

- Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж 400.0 сая төгрөг,
- Боловсролын салбарын тоног төхөөрөмж 1,150.0 сая төгрөг,
- Орон нутаг судлах танхимын тоног төхөөрөмж 65.0 сая төгрөг,
- Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төслийн хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмж 834.9 сая төгрөг,
- Эрүүл мэндийн салбарын автомашин, тоног төхөөрөмж 700.0 сая төгрөг байна.

1.6 Төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн гол үзүүлэлт болох эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг үнэн зөв, бодитой тооцоогүй нь хэрэгцээ, шаардлагаас давсан хөрөнгө оруулалт хийгдэх эрсдэл үүсэхээр байна.

1.7 Энэ нь аймгийн Засаг даргын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлсэн жагсаалтаас төсөл, арга хэмжээг төсвийн тухай хуульд тусгахгүй байгаатай холбоотой байна.

1.8 Мөн аймгийн бодлогын хэлтсүүд, улсын төсвийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй, шаардлагатай тоног төхөөрөмжийг зөв тодорхойлоогүй, нэгдсэн судалгаагүй байгааг харуулж байна.

1.9 “Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл (Өмнөговь) ХХААХҮЯ/20240102039, УТ2401900354 дугаар багц-1”-ийн хүрээнд нэг бүр нь 5.5 сая төгрөгийн өртөгтэй 35 зуны хүлэмжийг иргэдэд үнэ төлбөргүй олгохоор төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

1.10 Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3²-т заасантай нийцэхгүй байна. Иймд зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлээ.

БҮЛЭГ 2. ЗАХИАЛАГЧ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТЫГ БОЛОВСРУУЛАХДАА САЛБАРЫН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙГ ОРОЛЦУУЛЖ БАЙХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжихээр эрх шилжсэн нийт 8 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг аймгийн Худалдан авах ажиллагааны газар, 2 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Ус, цаг уур, орчны шинжилгээний төв тус тус зохион байгуулсан байна.

2.2. Эрх шилжиж шинээр хэрэгжүүлэх 10 төсөл, арга хэмжээний зарим төсөл, арга хэмжээг төрлөөс нь хамааруулан багц болгон задалж нийт 14 худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

Хүснэгт 3 Төсөл, арга хэмжээний мэдээлэл

№	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Эрх шилжүүлсэн шийдвэр		Үнэлгээний хороо байгуулсан огноо	Тендер анх зарласан огноо	Тендер шалгаруулалт зохион байгуулсан удаа	ХАА-нд мөрдөгдсөн журам
			Огноо	Дугаар				
1	ЗГХЭГ-ын сайд	Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Өмнөговь/	2024.01.30	11	2024.04.09	2024.05.13	1	НТШ
2	БОУА Ө-сайд	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/	2024.10.07	A/371	2024.10.16	2024.10.18	1	НТШ
3	БОУА Ө-сайд	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилгын их засвар, цахилгааны монтаж, халаалтын зуухыг шинэчлэх /Өмнөговь, Даланзадгад/	2024.01.19	A/38	2024.07.26	2024.07.26	1	Гэрээ шууд байгуулах
4		Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Архивын барилгын дээврийн засвар /Өмнөговь, Даланзадгад/	2024.01.19	A/38	2024.10.10	2024.10.10	1	Гэрээ шууд байгуулах
5	Боловсролын сайд	Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Өмнөговь/ Багц 1	2023.12.05	A/550	2024.04.29	2024.05.13	1	НТШ
6		Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Өмнөговь/ Багц 2	2023.12.05	A/550	2024.04.29	2024.05.13	1	НТШ
7	ГБХНХ-ын сайд	Буянт хотхон хүүхдийн зуслангийн өвлийн байр, 250ор /Өмнөговь, Даланзадгад сум/	2024.01.22	409	2024.02.20	2024.03.12	4	НТШ
8	ССАЖ 3-ын сайд	Орон нутаг судлах танхимын тоног төхөөрөмж /Ноён сум/	2023.12.15	A/499	2024.05.02	2024.07.05	4	НТШ
9		Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /багц 1/	2024.01.11	A/14	2024.04.29	2024.05.27	1	НТШ

2 Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно.

10	ХХАА ХҮ-ын сайд	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Багц 2/	2024.01.11	A/14	2024.04.29	2024.05.27	4	НТШ
11	Эрүүл мэндийн сайд	Зооноз өвчин судлалын төвийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/	2024.01.09	A/12	2024.04.08	2024.04.17	4	НТШ
12	Эрүүл мэндийн сайд	Эрүүл мэндийн салбарын автомашин, тоног төхөөрөмж /Өмнөговь/ Багц 1	2024.01.09	A/12	2024.04.29	2024.04.30	1	НТШ
13		Эрүүл мэндийн салбарын автомашин, тоног төхөөрөмж /Өмнөговь/ Багц 2	2024.01.09	A/12	2024.04.29	2024.04.30	1	НТШ
14		Эрүүл мэндийн салбарын автомашин, тоног төхөөрөмж /Өмнөговь/ Багц 3	2024.01.09	A/12	2024.04.29	2024.04.30	1	НТШ

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

2.3. Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.1³-т заасан эрх шилжүүлэх хугацааг ГБХНХ-ын сайд 2, ЗГХЭГ-ын сайд 10 хоногоор хоцроосон байна.

2.4. Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй, цахим хэлбэрээр 12 төсөл, арга хэмжээг НТШ, 2 төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулах аргаар зохион байгуулсан байна.

2.5. Эрх шилжсэн 14 төсөл, арга хэмжээнээс 13 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг тайлант онд хэрэгжих боломжтой байдлаар зохион байгуулагдсан байна.

2.6. Харин орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төслийн хүрээнд "Тусгай зориулалтын машин, тоног төхөөрөмж нийлүүлэх /Багц-2/"-н шалгарсан оролцогчтой гэрээ байгуулаагүй, Аймгийн засаг даргын Тамгын даргын 2024 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн 02/2006 дугаар албан бичгээр захиалагч тендерийн баримт бичиг ажлын даалгаварт ажлын тоо хэмжээг оруулаагүй гэх шалтгаанаар худалдан авах ажиллагааг хүчингүй болгосон байна.

2.7. Мөн орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төслийн хүрээнд "Тусгай зориулалтын машин, тоног төхөөрөмж нийлүүлэх /Багц-2/" 383.0 сая төгрөгийн төсөвтэй төсөл, арга хэмжээний ажлын даалгаврыг захиалагч боловсруулахдаа ажлын тоо, хэмжээг оруулаагүйн улмаас тендер сонгон шалгаруулалтыг 4 удаа зохион байгуулах шалтгаан болсон байна.

2.8. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3⁴, 30.3.2⁵, 48 дугаар зүйлийн 48.2⁶, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1⁷-д заасантай тус тус нийцэхгүй байна.

³ Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тухайн жилийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор багтаан дараах эрхээ доор дурдсаны дагуу шилжүүлж болох бөгөөд энэ талаар гаргасан шийдвэрээ ажлын 5 хоногт багтаан цахим системд оруулж баталгаажуулна.

⁴ Захиалагч доор дурдсанаас бусад тохиолдолд шалгарсан оролцогчтой гэрээ байгуулна.

⁵ энэ хуульд заасан гомдол хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллага, эсхүл шүүхийн шийдвэрээр тендер шалгаруулалтыг түдгэлзүүлсэн, гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг хүчингүй болгосон, эсхүл тендер шалгаруулалтыг хүчингүйд тооцсон.

⁶ Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

⁷ зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах.

2.9. Иймд зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

Хүснэгт 4 Төсөл, арга хэмжээний мэдээлэл

/сая төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн	Шалгар сан дүн	Тендерийн хэмнэлт /4-6/
		Эхлэх	Дуусах				
	1	2	3	4	5	6	7
1	Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Өмнөговь/	2024	2024	400.0	400.0	340.0	60.0
2	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/	2024	2026	2,512.5	850.0	2,410.8	101.7
3	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилгын их засвар, цахилгааны монтаж, халаалтын зуухыг шинэчлэх /Өмнөговь, Даланзадгад/	2024	2024	20.0	20.0	20.0	0
4	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Архивын барилгын дээврийн засвар /Өмнөговь, Даланзадгад/	2024	2024	20.0	20.0	20.0	0
5	Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Өмнөговь/ Багц 1	2024	2024	580.7	580.7	491.6	89.1
6	Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Өмнөговь/ Багц 2	2024	2024	569.3	569.3	455.4	113.9
7	Буянт хотхон хүүхдийн зуслангийн өвлийн байр, 250ор /Өмнөговь, Даланзадгад сум/	2024	2026	3,057.9	500.0	3,053.5	4.4
8	Орон нутаг судлах танхимын тоног төхөөрөмж /Ноён сум/	2024	2024	65.1	65.1	43.4	21.7
9	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /багц 1/	2024	2024	451.9	451.9	387.1	64.8
10	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /багц 2/	2024	2024	383.0	383.0	375.0	8.0
11	Зооноз өвчин судлалын төвийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/	2024	2026	3,427.7	1,000.0	3,318.5	109.20
12	Эрүүл мэндийн салбарын автомашин, тоног төхөөрөмж /Өмнөговь/ Багц 1	2024	2024	587.0	587.0	436.6	150.4
13	Эрүүл мэндийн салбарын автомашин, тоног төхөөрөмж /Өмнөговь/ Багц 2	2024	2024	38.0	38.0	22.9	15.1
14	Эрүүл мэндийн салбарын автомашин, тоног төхөөрөмж /Өмнөговь/ Багц 3	2024	2024	75.0	75.0	71.4	3.6
Нийт дүн				12,188.1	5,540.0	11,446.2	741.9

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

2.10. Худалдан авах ажиллагааны үр дүнд нийт 741.9 сая төгрөгийн тендерийн хэмнэлт бий болсон байна.

2.11. Хэдийгээр тендерийн хэмнэлт бий болгож төсөвт үүсэх ачааллыг бууруулж байгаа ч нөгөө талаар төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг үндэслэлгүй тооцох байгаатай холбоотой байна.

2.12. Иймд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, төсөвлөлтийг сайжруулах шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ АШИГЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

3.1 Эрх шилжиж шинээр хэрэгжих /багц болж задарсан/ 14, өмнөх оноос шилжиж ирсэн 1, нийт 15 төсөл, арга хэмжээг 2024 он санхүүжүүлэхээр тусгасан байна.

Хүснэгт 5 Төсөл, арга хэмжээний мэдээлэл

/сая төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн	2024 онд олгосон дүн	Хэрэгжиж дууссан эсэх
		Эхлэх	Дуусах				
1	Сургуулийн барилга, 320 суудал /Өмнөговь, Цогт-Овоо сум	2019	2025	4,664.3	542.3	1,046.8	Тийм
2	Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Өмнөговь/	2024	2024	400.0	400.0	340.0	Тийм
3	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/	2024	2026	2,512.5	850.0	-	Үгүй
4	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилгын их засвар, цахилгааны монтаж, халаалтын зуухыг шинэчлэх /Өмнөговь, Даланзадгад/	2024	2024	20.0	20.0	20.0	Тийм
5	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Архивын барилгын дээврийн засвар /Өмнөговь, Даланзадгад/	2024	2024	20.0	20.0	20.0	Тийм
6	Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Өмнөговь/ Багц 1	2024	2024	580.7	580.7	491.6	Тийм
7	Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Өмнөговь/ Багц 2	2024	2024	569.3	569.3	455.4	Тийм
8	Буянт хотхон хүүхдийн зуслангийн өвлийн байр, 250ор /Өмнөговь, Даланзадгад сум/	2024	2026	3,057.9	500.0	-	Үгүй
9	Орон нутаг судлах танхимын тоног төхөөрөмж /Ноён сум/	2024	2024	65.1	65.1	43.4	Тийм
10	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /багц 1/	2024	2024	451.9	451.9	387.1	Тийм
11	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /багц 2/	2024	2024	383.0	383.0	375.0	Тийм
12	Зооноз өвчин судлалын төвийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/	2024	2026	3,427.7	1,000.0	-	Үгүй
13	Эрүүл мэндийн салбарын автомашин, тоног төхөөрөмж /Өмнөговь/ Багц 1	2024	2024	587.0	587.0	436.6	Тийм
14	Эрүүл мэндийн салбарын автомашин, тоног төхөөрөмж /Өмнөговь/ Багц 2	2024	2024	38.0	38.0	22.9	Тийм
15	Эрүүл мэндийн салбарын автомашин, тоног төхөөрөмж /Өмнөговь/ Багц 3	2024	2024	75.0	75.0	71.4	Тийм
Нийт дүн				12,188.1	5,540.0	3,710.1	

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

3.2 Он дамжиж хэрэгжих 3 барилга байгууламжаас бусад 12 төсөл, арга хэмжээ гэрээнд заасан хугацаандаа хэрэгжиж, гэрээг дүгнэсэн байна.

3.3 Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, Буянт хотхон хүүхдийн зуслангийн өвлийн байр, Зооноз өвчин судлалын төвийн барилгууд гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт нь хэд хэдэн удаа амжилтгүй болсноос шалтгаалан гэрээ байгуулах хугацаа хойшилсноос 2024 онд гүйцэтгэл гараагүй байна.

3.4 Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг журмын дагуу захиалагчийн хянаж баталгаажуулсан ажлын гүйцэтгэлийг үндэслэн олгосон байна. /Дэлгэрэнгүйг нэгдсэн судалгаа №3/

3.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, ашиглалын байдалд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- “Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл багц-1”-н хүрээнд нийлүүлэгдсэн 190.8 сая төгрөгийн /нэг бүр нь 5.5 сая/ өртөгтэй 35 зуны хүлэмжийг иргэдэд үнэ төлбөргүй, эргэн төлөгдөх нөхцөлгүй олгосон,

- “Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл багц-1”-н хүрээнд нийлүүлэгдсэн 196.3 сая /нэг бүр нь 98.2 сая/ төгрөгийн өртөгтэй 2 тракторыг одоог хүртэл ашиглаагүй,

Ашиглагдахгүй байгаа байдал



- “Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл багц-1”-н хүрээнд нийлүүлэгдсэн 98.2 сая төгрөгийн өртөгтэй 1 тракторыг бүртгэлд тусгаагүй байна.

3.6 Дээрх алдаа, зөрчлүүдэд дахин давтахгүй байх, зөрчлийг арилгах талаар албан шаардлага, ажил зохион байгуулах зөвлөмж хүргүүлээ.

3.7 Мөн “Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилгын их засвар, цахилгааны монтаж, халаалтын зуухыг шинэчлэх” ажилд гүйцэтгэгчтэй 20.0 сая төгрөгийн гэрээ шууд байгуулан гүйцэтгүүлсэн боловч засвар хийсэн барилга нь дахин засвар хийх шаардлагатай болсон байна.

Одоо байгаа байдал



3.8 Дээрх засварын ажлыг батлагдсан зураг, төсөвгүй хийсэн нь төсөвт өртөг хангалтгүй, зарим ажлыг дутуу хийснээс шалтгаалан үр дүнгүй ажил болсон байна.


3.9 Боловсролын салбарын тоног төхөөрөмж Багц 2-ын хүрээнд нийлүүлэгдсэн зарим тоног төхөөрөм болох угаалгын машин, тоос сорогч зэргийг зарим байгууллагууд одоог хүртэл ашиглаагүй байна.

Ашиглагдахгүй байгаа байдал



3.10 Эрүүл мэндийн салбарын автомашин, тоног төхөөрөмж Багц 1-ын хүрээнд нийлүүлэгдсэн зөөврийн, суурин компьютер зэргийг зарим байгууллагууд одоог хүртэл ашиглаагүй байна.

Ашиглагдахгүй байгаа байдал



3.11 Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл багц 2-ын хүрээнд нийлүүлэгдсэн УАЗ фургон маркийн автомашин мөн ашиглагдахгүй байна.

Ашиглагдахгүй байгаа байдал



3.12 Эрүүл мэндийн салбарын автомашин, тоног төхөөрөмж багц 3-ын хүрээнд нийлүүлэгдсэн УАЗ фургон маркийн автомашин 71.4 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл багц 2-ын хүрээнд нийлүүлэгдсэн УАЗ фургон маркийн автомашин 99.0 сая төгрөг буюу 27.6 сая төгрөгийн зөрүүтэй байна.

3.13 Дээрх 2 автомашин нь ижил он, техникийн тодорхойлолт нь адил байгаа боловч үнийн дүнгийн хувьд зөрүүтэй нийлүүлэгдсэн нь төсөвлөлтийг хангалтгүй хийсэнтэй холбоотой байна.

3.14 Иймд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, тэргүүлэх ач холбогдол, эдийн засгийн үр өгөөжөөр нь эрэмбэлж төлөвлөх шаардлагатай байна.

3.15 Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын үр дүнг тооцоож ажиллах шаардлага байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, тэргүүлэх ач холбогдол, эдийн засгийн үр өгөөжөөр нь эрэмбэлж төлөвлөөгүй байна.
- “Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл багц-1”-н хүрээнд нийлүүлэгдсэн 98.2 сая төгрөгийн өртөгтэй 1 тракторыг бүртгэлд тусгаагүй байна
- Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Н.ЭНХБАТ ТАНАА:

1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалтад дотоод хяналт хэрэгжүүлэн үр дүнг тооцож байх,
2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон 98.2 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгуулах талаар ажил зохион байгуулах

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/05

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ийн 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт" сэдэвт нийцлийн аудитын тайланг нэгдүгээр, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газар болон Өмнөговь аймгийн Засаг даргад тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Г.Шижирболд)-т үүрэг болгосугай.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Г.Шижирболд)-д даалгасугай.



Ц.ӨСӨХБАЯР

4625010019
F:\2 Бичиг хэрэг\2024 он\Тушаал төлөвлөгөө

